

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/70/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Ахлах аудитор Ц.Сааранчимэг

Утас: 70273204 Цахим хаяг: saranchimegts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал.....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Төлбөрийн акт.....	17
5.2 Албан шаардлага.....	17
5.3 Зөвлөмж	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.02.25 № 01/124
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант оны үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно. Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Япон улсын 2022 онд Жайка төслийн багийнхан Жаргалант суманд ирж сонгино тариалж ургуулах төслийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Төв аймгийн Жаргалант сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бэлчээрийн 4 худаг, 2 худгийн цахим тоног төхөөрөмж, гэрэлтүүлэг, Ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын талбайн хашаажуулалт, гэрэлт цамхаг, гүүр засвар, явган хүний зам суваг шуудууны засварын ажил, Ерөнхий боловсролын сургуульд төстийн машин, сүү хүлээн авах цэгийн тохижилтын ажил, зам засварын ажил зэрэг бүтээн байгуулалтын ажлууд хийгдсэн байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл байхгүй байна. Шинэ хөдөө төсөл хэрэгжиж хадуур, өвс хаман боогч, үрлүүр, трактор зэрэг бүрэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийг бүртгэл тайланд тусгасан байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал гараагүй болно. Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	71,703,045.44	85,898,082.46
33	АВЛАГА	1,510,200.00	1,510,200.00
33500	Бусад авлага	1,510,200.00	1,510,200.00
33510	Байгууллагаас авах авлага	1,510,200.00	1,510,200.00
35	БАРАА МАТЕРИАЛ	70,192,845.44	84,387,882.46
35100	Түүхий эд материал	6,869,558.00	6,523,558.00
35110	Тусгай зориулалттай материал	6,869,558.00	6,523,558.00
35400	Хангамжийн материал	63,323,287.44	77,864,324.46
35410	Бичиг хэргийн материал	582,200.00	461,200.00
35420	Аж ахуйн материал	2,015,200.00	2,015,200.00
35430	Сэлбэг хэрэгсэл	22,566,500.00	24,236,500.00
35440	Түлш, шатах тослох материал	1,708,463.00	3,392,000.02
35450	Барилгын засварын материал	756,600.00	857,400.00
35470	Бусад хангамжийн материал	35,694,324.44	46,902,024.44
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,874,852,537.66	2,513,785,145.17
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,874,852,537.66	2,513,785,145.17
39200	Биет хөрөнгө	1,722,548,537.66	2,325,194,185.13
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,386,170,923.32	1,478,581,423.32
39202	Хуримтлагдсан элэгдэл	-386,189,297.22	-436,625,032.02
39203	Авто-тээврийн хэрэгсэл	365,232,256.61	523,441,346.61
39204	Хуримтлагдсан элэгдэл	-240,520,416.87	-277,041,172.55
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	181,533,367.39	297,173,815.64
39206	Хуримтлагдсан элэгдэл	-132,831,952.83	-143,589,096.71
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	71,810,903.00	93,384,257.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-37,500,898.05	-37,045,440.37
39214	Бусад үндсэн хөрөнгө	716,602,884.00	1,090,839,437.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-201,759,231.69	-263,925,352.79
39300	Биет бус хөрөнгө	152,304,000.00	188,590,960.04
39301	Програм хангамж	450,000.00	450,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-450,000.00	-450,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	152,304,000.00	190,500,800.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	0	-1,909,839.96
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,946,555,583.10	2,599,683,227.63
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,946,555,583.10	2,599,683,227.63
51	Засгийн газрын хувь оролцоо	1,946,555,583.10	2,599,683,227.63
51100	Засгийн газрын оруулсан капитал	460,393,479.67	460,393,479.67
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	460,393,479.67	460,393,479.67
51200	Хуримтлагдсан үр дүн	775,063,202.96	1,428,345,663.68
51210	Өмнөх үеийн үр дүн	977,039,663.65	775,218,019.15
51220	Тайлант үеийн үр дүн	-201,976,460.69	653,127,644.53
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	711,098,900.47	710,944,084.28
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,946,555,583.10	2,599,683,227.63

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

			/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	569,046,856.10	1,426,837,044.82
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	95,351,272.10	781,892,869.00
120	Нийтлэг татварын бус орлого	95,351,272.10	781,892,869.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	80,172,494.10	767,209,869.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	15,178,778.00	14,683,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	473,695,584.00	644,944,175.82
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	65,041,734.00	147,202,438.82
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	18,350,000.00	0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны	43,675,234.00	124,615,873.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон	3,016,500.00	22,586,565.82
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	408,653,850.00	497,741,737.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	408,653,850.00	497,741,737.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	757,943,186.71	773,506,900.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	757,943,186.71	773,506,900.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	743,147,239.61	700,892,596.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	260,555,580.00	210,827,231.29
210101	Үндсэн цалин	159,047,537.47	182,519,514.54
210102	Нэмэгдэл	42,294,324.05	28,307,716.75
210105	Гэрээт ажлын хөлс	59,213,718.48	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,128,437.47	26,643,318.28
210201	Тэтгэврийн даатгал	25,486,851.37	18,369,900.54
210202	Тэтгэмжийн даатгал	2,784,526.14	2,068,379.43
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,164,974.34	1,654,683.55
210204	Ажилгүйдлийн даатгал	511,299.21	413,695.89
210205	Эрүүл мэндийн даатгал	5,180,786.41	4,136,658.87
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47,987,929.52	45,330,931.97
210301	Гэрэл, цахилгаан	12,340,494.88	11,766,902.96
210302	Түлш, халаалт	35,647,434.64	33,564,029.01
2104	Хангамж, бараа материалын зардал	33,762,749.92	34,710,089.97
210401	Бичиг хэрэг	3,748,278.00	2,070,000.00
210402	Тээвэр, шатахуун	11,330,175.00	20,879,239.97
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,368,410.00	1,300,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	12,797,886.92	6,843,350.00
210408	Бараа материал акталсны зардал	4,518,000.00	3,617,500.00
2105	Нормативт зардал	726,300.00	0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	726,300.00	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	661,000.00	2,863,424.00
210604	Урсгал засвар	661,000.00	2,863,424.00
2107	Томилолт, зочны зардал	538,000.00	2,333,000.00
210702	Дотоод албан томилолт	538,000.00	2,333,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,084,076.00	81,467,906.11
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,586,276.00	80,410,694.11
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.00	604,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	0	200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	750,000.00	186,412.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	143,000.00	66,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	335,703,166.70	296,716,694.49
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	73,813,969.64	120,025,833.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	261,889,197.06	176,690,861.49
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,795,947.10	72,614,304.18
2132	Бусад урсгал шилжүүлэг	400,000.00	68,682,967.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0	16,260,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0	51,812,967.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400,000.00	610,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас,	14,395,947.10	3,931,337.18
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,395,947.10	3,931,337.18
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-188,896,330.61	653,330,144.53
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	13,080,130.08	202,500.00
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	4,689,980.08	202,500.00
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	1,500,000.00	0
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	6,890,150.00	0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-201,976,460.69	653,127,644.53

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

		/төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	473,695,584.00	644,944,175.82
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	473,695,584.00	644,944,175.82
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	65,041,734.00	147,202,438.82
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	17,294,834.00	0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод	44,730,400.00	124,615,873.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон	3,016,500.00	22,586,565.82
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	408,653,850.00	497,741,737.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт	408,653,850.00	497,741,737.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	473,695,584.00	596,328,075.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	473,695,584.00	596,328,075.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	458,899,636.90	523,513,771.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	260,555,580.00	210,827,231.29
210101	Үндсэн цалин	159,047,537.47	182,519,514.54
210102	Нэмэгдэл	42,294,324.05	28,307,716.75
210105	Гэрээт ажлын хөлс	59,213,718.48	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,128,437.47	26,643,318.28
210201	Тэтгэврийн даатгал	25,486,851.37	18,369,900.54
210202	Тэтгэмжийн даатгал	2,784,526.14	2,068,379.43
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,164,974.34	1,654,683.55
210204	Ажилгүйдлийн даатгал	511,299.21	413,695.89
210205	Эрүүл мэндийн даатгал	5,180,786.41	4,136,658.87
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,130,961.88	48,576,758.96
210301	Гэрэл, цахилгаан	12,340,494.88	11,766,902.96
210302	Түлш, халаалт	30,790,467.00	36,809,856.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,483,071.92	30,745,300.00
210401	Бичиг хэрэг	2,700,600.00	1,982,000.00
210402	Тээвэр, шатахуун	11,616,175.00	20,213,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,368,410.00	1,300,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	12,797,886.92	7,250,100.00
2105	Нормативт зардал	926,100.00	0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	926,100.00	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	661,000.00	2,613,424.00
210604	Урсгал засвар	661,000.00	2,613,424.00
2107	Томилолт, зочны зардал	538,000.00	2,333,000.00
210702	Дотоод албан томилолт	538,000.00	2,333,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,011,076.00	81,467,906.11
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	25,513,276.00	80,410,694.11
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.00	604,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	0	200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	750,000.00	186,412.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	143,000.00	66,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	61,465,409.63	120,306,833.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	61,335,409.63	120,306,833.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	130,000.00	0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,795,947.10	72,814,304.18
2132	Бусад урсгал шилжүүлэг	400,000.00	68,882,967.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0	16,260,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0	51,812,967.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400,000.00	810,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас,	14,395,947.10	3,931,337.18
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,395,947.10	3,931,337.18
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	0	48,616,100.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0	48,616,100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0	48,616,100.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0	48,616,100.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0	48,616,100.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0	-48,616,100.00
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ	0	0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0	0
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	460,393,479.67	711,098,900.47	977,039,663.65	2,148,532,043.79
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	460,393,479.67	711,098,900.47	977,039,663.65	2,148,532,043.79
9	Тайлант үеийн үр дүн	0	0	-201,976,460.69	-201,976,460.69
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	460,393,479.67	711,098,900.47	775,063,202.96	1,946,555,583.10
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	460,393,479.67	711,098,900.47	775,063,202.96	1,946,555,583.10
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	154,816.19	154,816.19
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	460,393,479.67	711,098,900.47	775,218,019.15	1,946,710,399.29
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	-154,816.19	0	-154,816.19
19	Тайлант үеийн үр дүн	0	0	653,127,644.53	653,127,644.53
20	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	460,393,479.67	710,944,084.28	1,428,345,663.68	2,599,683,227.63

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

			/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	561,207,800.00	493,876,915.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	561,207,800.00	493,876,915.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	507,827,600.00	441,253,948.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	216,493,600.00	210,827,231.29
210101	Үндсэн цалин	177,308,900.00	182,519,514.54
210102	Нэмэгдэл	39,184,700.00	28,307,716.75
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,468,500.00	26,643,318.28
210201	Тэтгэврийн даатгал	19,054,200.00	18,369,900.54
210202	Тэтгэмжийн даатгал	2,103,600.00	2,068,379.43
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,682,900.00	1,654,683.55
210204	Ажилгүйдлийн даатгал	420,700.00	413,695.89
210205	Эрүүл мэндийн даатгал	4,207,100.00	4,136,658.87
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	68,291,700.00	48,576,758.96
210301	Гэрэл, цахилгаан	16,758,500.00	11,766,902.96
210302	Түлш, халаалт	51,374,600.00	36,809,856.00
210303	Цэвэр, бохир ус	158,600.00	0
2104	Хангамж, бараа материалын зардал	37,071,000.00	20,974,550.00
210401	Бичиг хэрэг	1,527,000.00	1,527,000.00
210402	Тээвэр, шатахуун	10,936,000.00	10,897,450.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,608,000.00	1,300,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	23,000,000.00	7,250,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,201,100.00	2,803,324.00
210604	Урсгал засвар	3,201,100.00	2,803,324.00
2107	Томилолт, зочны зардал	2,333,000.00	2,333,000.00
210702	Дотоод албан томилолт	2,333,000.00	2,333,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	77,279,000.00	71,819,189.11
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	75,259,000.00	70,761,977.11
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	604,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	400,000.00	200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	750,000.00	186,412.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	150,000.00	66,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	75,689,700.00	57,276,577.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	75,689,700.00	57,276,577.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	53,380,200.00	52,622,967.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	53,380,200.00	52,622,967.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	52,380,200.00	51,812,967.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	810,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	561,207,800.00	493,876,915.64
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0	0
310001	Улсын төсвөөс санхүүжих	0	0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	518,603,500.00	493,876,915.64
320001	Орон нутгийн төсвөөс	518,603,500.00	493,876,915.64
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	42,604,300.00	0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	42,604,300.00	0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	59,047,831.00	147,135,923.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	59,047,831.00	147,135,923.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	59,047,831.00	130,875,923.00
2104	Хангамж, бараа материалын зардал	420,275.00	9,770,750.00
210401	Бичиг хэрэг	245,000.00	455,000.00
210402	Тээвэр, шатахуун	175,275.00	9,315,750.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,513,276.00	9,648,717.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	25,513,276.00	9,648,717.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33114280.00	111456456.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,984,280.00	111,456,456.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	130,000.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	16260000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	16,260,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	16,260,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	65041734.00	147202438.82
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	65,041,734.00	147,202,438.82
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бүс этгээдээс авсан хандив,	18,350,000.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс	11,000,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод	32,696,234.00	124,615,873.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий	2,995,500.00	22,586,565.82
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын тамгын газар нь сумын ИТХ, Засаг даргын бодлого боловсруулж, шийдвэр гаргахад нь бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэх замаар төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэн төрийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, иргэдийн ажиллах амьдрах таатай орчин бүрдүүлэх, оновчтой бодлого зохицуулалтаар хангах замаар аймгийнхаа хөгжилд дэмжлэг үзүүлж чаддаг, цомхон чадварлаг, эцсийн үр дүнг эрхэмлэн дээдэлсэн төрийн албыг төлөвшүүлэх чиг үүрэг бүхий Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын харьяа төрийн байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд үйл ажиллагааг гүйцэтгэж байна. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Төрийн албаны тухай хууль
- Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Монгол Улсын Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын даргын 2022 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн А/12 тоот “Дотоод хяналт шалгалтын ажлын хэсэг байгуулах тухай” тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй томилогдсон байна.

Дотоод хяналт шалгалт хийх 12 арга хэмжээ төлөвлөж батлуулан, хяналт шалгалт хийх удирдамжийг тухай бүр батлуулан хэрэгжилтийг тайлагнаж ажилласан байна.

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын 2020, 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2022 онд шалгалт хийгдсэн байна. Шалгалтаар дутуу олгосон цалин төлүүлэх тухай, Илүү, дутуу олгосон ээлжийн амралтын цалин шийдвэрлүүлэх тухай нийт 413.1 мянган төгрөгийн төлбөрийн акт бичигдэж актыг бүрэн барагдуулсан байна.

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын тамгын газар нь 2019 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн А/13 дугаар тушаалаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчилэн баталж санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байна. Аймгийн ТЭЗ-ийн хэмжээнд мөрдөж ажиллах НББ-ийн бодлогын баримт бичиг боловсруулагдсан бөгөөд хэвлэлтээс гараагүй учир ЗДТГ-ын даргын тушаалаар батлагдсан бодлогын баримт бичгийг мөрдөж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 653,127.6 мянган төгрөгөөр буюу 33,5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	эхний үлдэгдэл	эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Авлага	1,510.2	1,510.2	-
Бараа материал	70,192.8	84,387.9	14,195.0
Нөөцийн бараа	-	-	-
Үндсэн хөрөнгө	1,874,852.5	2,513,785.1	638,932.6
Нийт хөрөнгө	1,946,555.6	2,599,683.2	653,127.6
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо	1,946,555.6	2,599,683.2	653,127.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө	1,946,555.6	2,599,683.2	653,127.6

Дээрх хүснэгтээс харахад: Тайлант онд 1,510.2 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй өмнөх оны авлага барагдуулаагүй байна.

Тайлант онд бараа материал дансны эхний үлдэгдэл 70,192.8 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 84,387.9 мянган төгрөг буюу 14,195.0 мянган төгрөгөөр өссөн нь бусад хангамжийн материал 11,207.7 мянган төгрөг, түлш, шатах тослох материал 1,683.5 мянган төгрөг, сэлбэг хэрэгсэл 1,670.0 мянган төгрөгөөр тус тус өссөнөөс шалтгаалсан байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 1,874,852.5 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 2,513,785.1 мянган төгрөг болж, 638,932.6 мянган төгрөгөөр өссөн нь Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр 65,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий 4 бэлчээрийн худаг, Тал булаг худаг, салхит худагт 27,410.0 мянган төгрөгийн сайжруулалт, 309,379.1 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө, 20,000.0 мянган төгрөгийн ковш трактор, 56,309.1 мянган төгрөгийн трактор, Аймгийн цагдаагийн газраас 4,500.0 мянган төгрөгийн элентра маркийн авто машин шилжин ирсэн, албан хаагчдыг тоног төхөөрөмжөөр хангах зорилгоор 7,085.6 мянган төгрөгийн үнэ бүхий 2 нөөтбүүк, 1 өнгөт принтер, нийгмийн хариуцлагын гэрээгээр нийт 10,899.9 мянган төгрөгийн 3 компьютер тоног төхөөрөмж, бусад эх үүсвэрээс 48,181.8 мянган төгрөгийн өвс хаман боогч, 33,463.6 мянган төгрөгийн үрлүүр, 24,227.3 мянган төгрөгийн хадуур, аймгийн хөрөнгө оруулалтаар 27,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий хөдөлмөр зуслангийн 10 ширхэг гэр, төсвийн хөрөнгөөр 189.9 мянган төгрөгийн сандал, 10,941.0 мянган төгрөгийн наадмын талбайн сүүдрэвч, 3,396.9 мянган төгрөгийн нарс модны суулгац зэргээр хөрөнгө орлого авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,599,683.2 мянган төгрөг болж 653,127.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх эх үүсвэрийг 552,042.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 44,325.1 мянган төгрөгөөр бууруулан 507,717.5 мянган төгрөгөөр орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр батлан ирүүлсэн байна. Тус байгууллагын батлагдсан төсөвт Төсвийн ерөнхийлөн захирагчийн бүрэн эрхийн хүрээнд тодотгол хийж 53,490.3 мянган төгрөгөөр нэмэгдэж 561,207.8 мянган төгрөг болж өөрчлөгдсөн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийг төслийг 9,165.2 мянган төгрөгөөр нэмж 561,207.8 мянган төгрөгөөр батлан ирүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 8 арга хэмжээг 561,207.8 мянган төгрөгөөр орон нутгийн төсвийн санхүүжилтээр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 493,876.9 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 3,864.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 493,876.9 мянган төгрөг буюу 89,6 хувьтай байгаа нь орон нутгийн орлогын төлөвлөгөө тасарснаас 67,330.9 мянган төгрөгөөр эх үүсвэрийг дутуу санхүүжүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70106-80101	291,747.6	256,914.5	34,833.15	88.1
2	70106-80103	27,873.0	24,806.3	3,066.68	89.0
3	70106-80106	130,676.0	119,742.3	10,933.67	91.6
4	70106-80802	53,380.2	52,623.0	757.23	98.6
5	70106-81102	5,000.0	3,700.0	1,300.00	74.0
6	70106-82801	5,000.0	5,000.0	0.00	100.0
7	71411- 81701	24,531.0	23,840.8	690.25	97.2
8	71411- 82212	23,000.0	7,250.1	15,749.90	31.5
Дүн		561,207.8	493,876.9	48,833.5	89.6

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө 27 арга хэмжээ батлагдаж 95,2%-тай хэрэгжиж дүгнэгдсэн байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын тамгын газар нь тайлант онд Төв Чандмань ДЭХГ-аас 9,649.7 мянган төгрөгийн ундны усны нөхөн төлбөр, хуулийн дагуу сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн албан хаагчдын 16,260.0 мянган төгрөгний тэтгэмж, сумын онцгой комиссын шуурхай штабын автомашин шинэчлэхэд 60,000.0 мянган төгрөг, Статистикийн хэлтсээс ХАА-н тооллогын урамшуулал 12,259.0 мянган төгрөг, Газрын дуудлага худалдааны орлогоос аймгаас хуваарилсан 9,446.4 мянган төгрөг, ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансны шилжих үлдэгдэл 9,809.3 мянган төгрөг, сумын Хөдөлмөр зуслангийн ажлын санхүүжилт болох 27,000.0 мянган төгрөгийн нийт 147,202.4 мянган төгрөгийн орлого нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн байна. Нэмэлт санхүүжилтийн данснаас бичиг хэргийн зардалд 455.0 мянган төгрөг, тээвэр шатахуунд 9,315.7 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил

үйлчилгээний төлбөр хураамж 9,648.7 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 111,456.5 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлэг 16,260.0 мянган төгрөг, 66,5 мянган төгрөгийг татан төвлөрүүлж 147,202.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 2 хөтөлбөрийн 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	/мянган төгрөгөөр/		
				Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2022.01.01-2022.12.31	Төр засгийн бодлого шийдвэрийг сурталчилж, хэрэгжилтийг хангах, иргэдэд төрийн үйлчилгээг чанартай хүртээмжтэй хүргэнэ.	90.1	513,676.8	462,786.1
2	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	2022.01.01-2022.12.31	Нийтийн эзэмшлийн хог хаягдлыг цэвэрлэн хогийн цэгийн үйл ажиллагааг хэвийн явуулна.	65.4	47,531.0	31,090.9
Нийт дүн				77.8	561,207.8	493,876.9

Орон нутгийн орлого тасарч, санхүүжилт бүрэн хийгдээгүй нь хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ 77.8 %-ийн хэрэгжилттэй тайлагнахад нөлөөлсөн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой зөвлөмж өгөгдсөн болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Саранчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн №03/27 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг Жаргалант сумын ИТХ-ын баталсан 2022 оны төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Жаргалант сумын ИТХ-ын баталсан 2022 оны төсвийг, суурь үзүүлэлтийг төсвийн гүйцэтгэлийн тайлангийн 2022 оны 773,506.9 мянган төгрөгийн нийт зардлаас 1,5 хувиар буюу 7,615.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 5,711.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын тамгын газар нь тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тооцохдоо өмнөх оны батлагдсан төсөвтэй тайлант оны батлагдсан төсвийг харьцуулан дүн шинжилгээ хийхэд 60,004.3 мянган төгрөгөөр батлагдсан төсөв өссөн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын тамгын газар нь шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аудит хийхэд мэдээлсэн байдлын хэрэгжилт 96,1%-тай, мэдээллийг байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдэж алдаа зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар харилцагч байгууллагатай хийсэн 47,338.8 мянган төгрөгийн худалдан авалтыг татварын цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, төрийн сангийн харилцах данснаас касст орлого авахдаа арилжааны банкны дансаар дамжуулан хийсэн 2,753.1 мянган төгрөгийн гүйлгээг тайлагнаагүй зөрчилд албан шаардлага өгөгдсөн, бусад зардлын тооцооны авлага 1,510.2 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй зөрчилд зөвлөмж өгсөн байна. Албан шаардлага, зөвлөмжийг 100,0 % хэрэгжүүлэн Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 07/Б53 тоот албан бичгээр хэрэгжилтийг гарган ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	50,092.0	2	50092	100.0
Зөвлөмж	1	1,510.2			
Нийт дүн	3	51602.2	2	50092	66.7

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Бараа материалын зарцуулалтаас шатахууныг нарийвчлан шалгах

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,864.8 мянган төгрөгийн алдаа¹ залруулагдсан болно.

Залруулсан алдаа

Илрүүлэлт: Төсвийн гүйцэтгэлийн тайланд санхүүжүүлэх эх үүсвэрийг татан төвлөрүүлсэн 3,864.8 мянган төгрөгөөр тохируулаагүй алдаатай тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар” -ын 8 дугаар заалтыг болон санхүүгийн тайлангийн аудитын “оршин байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 15,053.1 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 2,086.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 12,967.1 мянган төгрөгийн зөвлөмж хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

1. Төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн.

Илрүүлэлт: Насжилт өндөртэй 1,510.0 мянган төгрөгийг барагдуулах зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” бол төлбөрийн акт тогтоох гэсэн дагуу шийдвэрлэв.

2. Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй олгосон

Илрүүлэлт: ЗДТГ-ын даргын 2022 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн Б/38 тоот тушаалаар 2 албан хаагчид 40%-ийн урамшуулал 575.8 мянган төгрөг олгосон байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3-д “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” бол төлбөрийн акт тогтоох гэсэн дагуу шийдвэрлэв.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

1. Арвилан хэмнэлт, үр нөлөө, үр ашигтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Шатахууны зардал өмнөх онд 36,768.3 мянган төгрөг зарцуулсан бол 2022 онд 49,735.4 мянган төгрөг зарцуулж 12.967.1 мянган төгрөгөөр буюу 35,3 хувиар өссөн байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд дараах арга хэмжээг авч ажиллана”, 15.2.3-д “сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Улаанбаатар хотод болон аймгийн төвд жийп ангиллын автомашины хэрэглээг хязгаарлах замаар тээвэр шатахууны зардлыг хэмнэж үр дүнд хүрч ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Өмнөх оны эцсийн үлдэгдэлээр насжилт өндөртэй, 1,520.2 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг барагдуулаагүй байна.	1	1,510.2	1	1,510.2	-	-	-	-	-	-	-	-
ЗДТГ-ын 2022 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн Б/38 тоот тушаалаар 2 албан хаагчид 40%-ийн урамшуулал олгосон	1	575.8	1	575.8	-	-	-	-	-	-	-	-
Шатахууны зардал өмнөх оноос 12,967.1 мянган төгрөгөөр өссөн байна.	1	12,967.1	-	-	-	-	1	12967.1	-	-	-	-
Нийт дүн	3	15,053.1	2	2,086.0	-	-	1	12,967.1	-	-	-	-